

БУЛГАН АЙМАГ

“Бүтээмж Сар” аяны тайлан

2014 он

“БҮТЭЭМЖ САР” АЯНЫ ЕРӨНХИЙ ТАЙЛАН

2014.2.12

Булган

Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2012 оны 11-р сарын 17-ны өдрийн 05 дугаар тогтоол, Аймгийн Засаг Даргын 2014 оны 01-р сарын 24-ний өдрийн 01 тоот албан даалгаврын дагуу Аймгийн хэмжээнд бүтээмжийн хөдөлгөөнийг өрнүүлэн ажиллаж байгаа бөгөөд уг ажлын хүрээнд хийгдэж буй ажлын нэг болох “Бүтээмж сар” аяныг 2014.01.10-с 2014.02.10-ны өдрүүдэд зохион байгуулав.

Энэ ажлын хүрээнд аймаг орон нутагт үйл ажиллагаагаа явуулж буй байгууллага, аж ахуйн нэгжүүдэд “Бүтээмж”-ийн талаарх нэгдсэн ойлголтыг өгөх, бүтээмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны эхлэл тавих ажил хийгдлээ.

Сарын аяныг явуулснаар 15 байгууллага, 15 сум бүтээмж хариуцсан ажилтанг албан ёсоор томилсон байна.

Сарын аяны хүрээнд хийсэн ажлын тайланг ирүүлэхийг 22 байгууллага, 16 сум, 1 тосгонд албан ёсоор мэдэгдсэнээс 14 байгууллага, 15 сум тайлангаа ирүүлсэн байна.

Аяны хүрээнд:

Ажил үйлчилгээний бүтээмж дээшлүүлэх Аймгийн Засаг Даргын албан даалгавар, БИАЗ-өөс сарын аяны төлөвлөгөө, удирдамжийг тус тус гаргуулан нийт сумд, хэлтэс, агентлаг, АОЭХ, ҮЭ –д хүргүүлэв.

Удирдамж, чиглэл гаргаснаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллалаа.

Бүтээмжийн чиглэлээр сумдын дарга, хэлтэс, агентлагийн дарга нарт сургалт зохион байгуулсан бөгөөд сургалтыг МБТ-ийн зөвлөх эксперт Б.Уранчимэг, эксперт Д.Баянцэцэг нар удирдан явуулав. Сургалтыг “Бүтээмж ба бүтээмж дээшлүүлэх тулгуур асуудлууд” сэдвээр явуулсан ба сургалтанд нийт 57 ажилтан, албан хаагчид хамрагдав.





Стандарт хэмжилзүйн хэлтсээс “Ажилтны харилцааны соёл, хувцаслалтанд тавих шаардлага” С5 11-0182:2012 байгууллагын стандартыг гарган нийт байгууллагуудад хүргүүлэн мөрдлөг болгон ажиллуулахаар үүрэг өгөн ажиллаж байна.

2014 оны 1 дүгээр сарын 18-нд БИАЗ ээлжит хуралдаан хийж цаашид хийх ажлын төлөвлөгөө гарган ажиллалаа.

БИАЗ нь 2014 онд МБТ-тэй хамтран ажиллах санал солилцож, “Булган аймгийн хэмжээнд Бүтээмж-Инновацийн хөдөлгөөн өрнүүлэх ажлын хөтөлбөр 2014-2016” хөтөлбөр боловсруулж, хамтран ажиллах санамж бичиг хүргүүлээд байна.



Бүтээмж дээшлүүлэх арга техникийг хэрэгжүүлэх сум, байгууллагыг сонгон ажиллаж байна. Үүнд: Хангал, Бүрэгхангай сум, АЗДТГ, ХХ, ХГБХХ, ГХБХБГ, СХЗХ зэрэг байгууллагууд сонгогдон ажлаа эхлүүлээд байна.

Сум, байгууллагын хэмжээнд хийсэн ажлуудаас дурдвал:

Онцлох нь: Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс бүтээмж дээшлүүлэх хэрэгсэл “5С” хэрэгжүүлэх болон байгууллагынхаа ажилтнуудын чөлөөт цагийг өнгөрүүлэх, ажиллах орчин нөхцлөө эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн сайжруулах зорилт тавьж, ажлын байрны сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, шинэ санааны булан, 7 хоногт “COOK TIME” хийх зэрэг хөтөлбөрүүдийг бодит ажил болгон амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.

Рашаант сум, ССАЖГ, Боловсролын газар зэрэг байгууллагуудын гаргасан жилийн ажлын төлөвлөгөө нь бүтээмж хэрэгжүүлэх ажилд бодитой, үр дүнгээ өгөхуйц төлөвлөгөө болсон ба Рашаант сумын хувьд сумын Засаг Даргын захирамж гаргуулан байгууллага тус бүртээ хариуцсан ажилтан томилон ажлын байрны тодорхойлолтонд хийх ажил үүргийг тусгуулан, сумандаа хэрэгжүүлж ажиллах жишиг байгууллагаа сонгон ажлаа эхлүүлсэн байна.

Бусад сум, байгууллагууд бүтээмж хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулах, бүтээмж хариуцсан ажилтанг томилох, ажлын байрны тодорхойлолтонд тусгуулах, 2014 онд хийх

ажлын төлөвлөгөө гаргах, бүтээмж, чанарын дугуйлан байгуулах зэргээр үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна.

Хөдөлмөрийн хэлтсийн зүгээс ССАЖГ, ГХБХБГ, Булган сум, Хөдөлмөрийн хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Байгаль орчны алба зэрэг 6 байгууллагад бүтээмжийн чиглэлээр сургалт зохион байгуулж, нийт 84 албан хаагчдыг хамруулав.





Түүнчлэн цаашид ОБГ, Татварын хэлтэс, Үйлдвэр ХАА-н газар, Орхон сум сургалт авахаар төлөвлөөд байна.

Сумдын хэмжээнд бүтээмжийн ажлын хэсгийг сумдын Засаг даргын орлогчоор ахлуулан, нарийн бичгийн даргаар сумын ХХМА-г томилон 7-9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллаж хөтөлбөр, төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тайлан мэдээгээ хугацаанд нь ирүүлээгүй АЗДТГ, НДХ, НХҮХ, ШШГА, ШША зэрэг байгууллагууд, Баян-Агт, Гурванбулаг зэрэг сумд цаашид бүтээмжийн ажлыг өрнүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

ХӨДӨЛМӨРИЙН ХЭЛТЭС